

**“ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ОРЧИН ҮЕИЙН АСУУДЛУУД-2021”
СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛААС ГАРГАСАН**

ЗӨВЛӨМЖ

Монголын Хүүхдийн ордноос ”Хүүхэд хөгжлийн орчин үеийн асуудлууд-II” Олон улсын эрдэм шинжилгээний Хоёрдугаар хурлыг 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулав.

Хуралд яамдууд, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, Төрийн болон төрийн бус байгууллага, ОХУ, БНСУ, АНУ, Япон улсын нийт 134 эрдэмтэн судлаачид оролцсон.

Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих, хүүхдийг хөгжүүлэх аливаа асуудалд шинжлэх ухаанчаар хандахад хувь нэмэр оруулах зорилготойгоор ”Хүүхэд хөгжлийн орчин үеийн асуудлууд” Олон Улсын эрдэм шинжилгээний Анхдугаар хурлыг 2018 онд Монголын хүүхдийн ордны түүхт 60 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан бөгөөд цаашид 2 жил тутамд хийж байхаар тогтсон юм.

Энэ удаагийн хурлыг танхим болон цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд танхимаар 78 хүн, цахим zoom платформоор Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, НЭДТГ, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийслэлийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Нийслэлийн Эрүүл мэндийн Үндэсний төв, МУИС, МУБИС, АШУУИС, ДХИС болон ”Хөөрхөн шар шувуу” төрийн бус байгууллага, “Мета” сэтгэл судлалын хүрээлэн зэрэг байгууллагын 60 орчим эрдэмтэн, судлаач, мэргэжилтэн оролцлоо.

Олон Улсын эрдэм шинжилгээний Хоёрдугаар хурал Үндсэн болон 5 салбар хуралдаанаар нийт 38 илтгэлийг хэлэлцсэн.

Хуралд оролцогчдоос гарсан санал, дүгнэлтэд үндэслэн хүүхдийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай асуудлаар дараах зөвлөмжийг гаргав.

Нэг. Эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлд:

1. Хүүхдийн бие бялдар, ёс суртахуун, гоо зүйн боловсролд анхаарах, соён гэгээрүүлэх ажлын цар хүрээг нэмэгдүүлэх, гэр бүлээрээ жүжиг, кино үзэх, зарим үед улсаас зохион байгуулж, үнэгүй үзүүлэх, номын санд ном унших боломжоор хангах, урлаг, спортоор дамжуулан тал бүрийн хүмүүжил олгох асуудлыг Төрийн бодлогын төвшинд авч үзэхийг санал болгож байна.
2. Хүүхэд багачуудад Монголын дэвшилтэд уламжлалт ёс заншлын контент хангалттай биш байна. Хүүхэд, ёсвөр насны хүүхдүүдийн сонирхол, амьдралын хэв маяг, хүлээн авч буй мэдээллийг гүнзгийрүүлэн судлах;
3. Хүүхэд залуучуудын бие бялдын ёсөлт хөгжилтийг судалдаг антропологийн шинжлэх ухааны салбар болох ”Ауксолология” нь манай Монгол оронд төдийлөн сайн хөгжөөгүй, энэ талаар улсын хэмжээний судалгаа хомс байна. Иймд энэ чиглэлд судалгааг нэмэгдүүлэх;

Хоёр. Үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт:

4. Өнөөдөр манай хүүхэд, залуучууд компьютер тоглоомын газар ихэнх цагаа өнгөрүүлж, гар утас, компьютерийн дэлгэц их ширтэж байна. Тэдэнд амьд харилцаа чухал юм. Тэдэнд зориулсан спортын ордон цогцолборууд, тоглоомын талбайг нэмэгдүүлэх, урлаг, спортоор хичээлэх боломжийг гаргаж өгөх хэрэгтэй байна. Дугуйлан, секцүүдийг үнэгүй болговол маш олон хүүхдүүд хамрагдах боломжтой.
5. Манайд цөөн тооны эрдэмтэд хүүхдийн өсөлт хөгжилтийн судалгааг явуулдаг боловч эдгээр нь тус тусдаа биеэ даасан, системгүй, нэгдмэл бус байгааг судалгааны Төр, захиргааны байгууллагууд анхаарч бодлогодоо тусгаж анхаарах;
6. Хүүхэд, өсвөр үеийнхний бие бялдрын хөгжилтийн судалгааг хоёр жил тутам эрдэмтэдийн тусламжтайгаар улсын хэмжээнд зохион байгуулж хэвшүүлэх, гарсан үр дүнг харгалзан үзэж, авах арга хэмжээг Засгийн газрын бодлогод тусгадаг байхыг санал болгож байна.
7. Хүүхдийн өсөлт, хөгжлийн онцлогт тохирсон хоол тэжээлийг сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдэд хэрхэн өгч байгаад анхаарал хандуулж, хүүхдийн нас, биеийн жинд тохирсон зохистой хэрэглээ, илүүдэл жин, таргалалтын талаар мэдээлэл, мэдлэгийг эцэг эх, олон нийт, боловсролын үйлчилгээ эрхлэгчдэд олгох;

Гурав. Хүүхэд хөгжил, хамгааллыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

8. Эцэг, эхчүүд хүүхдэдээ зориулж үр нөлөө өгөхүйцээр цаг гаргаж, харилцан ярилцах, хамтдаа тоглодог байх зэрэг энгийн дадлыг төлөвшүүлэх
9. Хүүхдийг зөв хүн болж төлөвших суурийг цэцэрлэгийн наснаас нь эхлүүлж, сөрөг нөлөөтэй кино, видео контентуудыг аль болохоор үзүүлэхгүй байх нь гэмт хэрэг, хүчирхийллийг бууруулах суурь эхлэл болно.
10. Хүүхдэд бие даах, өөрийгөө хөгжүүлэх, өөрийн давуу талаа олж харахад, өөртөө итгэлтэй, амжилттай сурахад нөлөөлөх хөтөлбөр хэрэгжүүлэх.
11. Хүүхдийн байгууллагуудын салбар дундын харилцаа холбоог нягт уялдаатай байхад анхаарч, Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах

**Олон Улсын эрдэм шинжилгээний хурлын
оролцогсод**

**Монгол Улс, Улаанбаатар хот
2021 оны 10 дугаар сарын 28-ны өдөр**